



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

┌ Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг ┐  
үе шаттайгаар нэмэгдүүлэх хуваарь  
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.


ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ

1518000135

Санхүүгийн зохицуулах хорооны  
2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн  
70 дугаар тогтоолын хавсралт



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН  
ДООД ХЭМЖЭЭГ ҮЕ ШАТТАЙ НЭМЭГДҮҮЛЭХ ХУВААРЬ

(сая төгрөгөөр)

Огноо	Улаанбаатар хот	Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан, Төв аймгийн Зуунмод сумдад	Бусад аймаг, сумдад
2026.04.10	3,500.0	900.0	300.0
2028.04.10	5,000.0	1,200.0	400.0

ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ  
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН  
ДООД ХЭМЖЭЭГ ҮЕ ШАТТАЙ НЭМЭГДҮҮЛЭХ ХУВААРЬ

(сая төгрөгөөр)

Огноо	Дүн
2026.04.10	5,000.0
2028.04.10	10,000.0

----oO----